



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

“Практикал даатгал” ХХК-ийн эрх бүхий албан  
тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-ийн Санхүү бүртгэлийн албаны даргаар Бархасын Хишигбаярыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. “Практикал даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах хүмүүсийг томилохыг зөвшөөрсүгэй:

№	Овог нэр	Албан тушаал
1	Тардайн Гантөмөр	ТУЗ-ийн дарга, Нэр дэвшүүлэх ба цалин урамшууллын хорооны дарга, стратегийн хорооны гишүүн
2	Чулуундоржийн Хашчулуун	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Стратегийн хорооны гишүүн
3	Дарамбазарын Ачит-Эрдэнэ	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Стратегийн хорооны дарга
4	Авирмэдийн Энхцэцэг	ТУЗ-ийн хараат гишүүн, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх ба цалин урамшууллын хорооны гишүүн
5	Гантөмөрийн Бүжин	ТУЗ-ийн хараат гишүүн, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх ба цалин урамшууллын хорооны гишүүн

3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг шинээр томилогдсон албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000447